



“Гоё тараг”-ийг хаана үйлдвэрлэдэгээ хэрэглэгчдэд харуулахаар болов

Нийтэлсэн огноо: 2014-02-26 15:49:21



“Витафит” компанийн “Оргил хүнс” охин компанийн удирдлагууд өнөөдөр хэвлэлийн бага хурал зарлаж, “Гоё тараг”-ийг Монгол Улсад өөрийн үйлдвэртээ үйлдвэрлэдэг гэдгийг хэлсэн юм. Сүүлийн үед олон нийтийн сүлжээний хэрэглэгчид “Гоё тараг”-ийг Хятадаас оруулж ирдэг хэмээн гарах болсон тул тус компанийнхан уг байдалд өөрсдийн байр сууриа илэрхийлж ташаа мэдээлэл цацагдсан гэдгийг тайлбарлав. Энэ ч үүднээс тус компанийнхан маргааш иргэд болон хэвлэл мэдээллийн байгууллагыг өөрийн үйлдвэрийн үйл ажиллагаатай танилцах боломжийг олгожээ. Олон нийтийн хэрэгсэлээр гарсан зургийн хувьд хувиараа бизнес эрхлэгч “Барс” худалдааны төвөөс авсан бараа бүтээгдэхүүнээ ачуулж байх үед зургийг дарсан гэнэ. “Оргил хүнс” компани дээрх гарсан мэдээлэлтэй холбогдуулан МХЕГ-ын Хилийн мэргэжлийн хяналтын газар, Хан-Уул дүүргийн МХГ, ГЕГ-ын статистикийн албанд гаалиар бараа бүтээгдэхүүн оруулж ирдэг эсэхийг шалгаж өгөх хүсэлтээ гаргасан байна. Энэ дагуу Гаалийн ерөнхий газраас тус компанийн нэр дээрх гаалийн бүрдүүлэлтийг шүүн үзэхэд тараг, иогурт импортлогдсон мэдээлэл гаалийн мэдээллийн санд бүртгэгдээгүй болно гэсэн хариу иржээ.

“Оргил хүнс” компанийн гүйцэтгэх захирал Н.Батзаяагаас цөөн хэдэн асуултанд хариулт авсан юм.

-Урьд нь “Сүүн бүтээгдэхүүн хэрэглэгчдийн төв” ТББ-аас удаа дараа “Гоё тараг”-ийг химийн бодис хэрэглэдэг гэсэн холбоотой мэдээлэл гарч байсан. Энэ тухайд танай компанийн зүгээс ямар мэдээлэл өгөх вэ?

-Жил хагасын өмнөөс манай бүтээгдэхүүний нэр хүндэд халдах болсон. Тухайн үед манай компаниас хууль хяналтын болон мэргэжлийн байгууллагад хандаж, үнэн зөвийг нь тогтоолгохоор болсон. Саяхан анхан шатны шүүхийн шийдвэр гарч “Сүүн бүтээгдэхүүн хэрэглэгчдийн төв” ТББ-ыг ажил хэргийн үйл ажиллагаанд үндэслэлгүй хандсан. Мэдээллийнхээ үнэн бодитой байдлыг баталж чадаагүй гэсэн дүгнэлт гарч, үйл ажиллагаанд хохирсон мөнгөн хохирлыг төлүүлэхээр болсон.

-Олон нийтийн сүлжээгээр гарсан мэдээлэл дээрх компанитай холбоотой болов уу?

-Яг тухайн байгууллага санаатайгаар ийм мэдээлэл түгээсэн эсэхийг мэдэхгүй байна. Гэхдээ энэ байдлаас харахад холбож үзэж ойлгохоос өөр арга байхгүй байна.

-“Гоё тараг”-ийг хэрхэн үйлдвэрлэдэг вэ?

-Манай компани 2009 байгуулагдсан. Тарагны үндсэн түүхий эд болох шингэн сүүг Хэнтий аймгийн Хэрлэн сумын Өлзийт тосгонд байрладаг “Атар чандгана сүү” компаниас жилийн гэрээгээр графикийн дагуу худалдаж авдаг. Тухайн сүүг хөргөлттэй автомашинаар тээвэрлэн Улаанбаатар хотод байрлах үйлдвэрт шууд нийлүүлдэг. Түүнчлэн өөрсдийн лого тэмдэгтэй тарагныхаа савыг өөрсдийн үйлдвэртээ үйлдвэрлэдэг. Хүсвэл манай үйлдвэртэй танилцаж болно.

Т.Сайнбуян



ОНЦЛОХ МЭДЭЭ




Хэнийх нь цом бэ

1 2 3 4

Шинэ	Их уншсан	Сэтгэгдэл
Даниэль Старриж шилдгээр тодорлоо		2014-03-18 11:55:57
Хойд Солонгост арга хэмжээ авахаар хэлэлцэж байна		2014-03-18 11:36:27
Л.Суарес шинэ гутлаараа гангарав		2014-03-18 11:36:31
Урьдчилгаа мөнгөгүй ч байртай болох боломж удахгүй нээгдэнэ		2014-03-18 11:06:40
Нийслэлийн Мал хамгаалах санг байгууллаа		2014-03-18 10:59:34
Хогны хураамжийн төлбөрөөр уут хийдэг		2014-03-18 10:47:49
Тавдугаар сард хоёр гүүрэн гарч ашиглалтанд орно		2014-03-18 10:41:00

БОЛОР ТОЛЬ

Bolor Dictionary



ВАЛЮТЫН ХАНШ			
Валют		Авах	Зарах
	USD	1753.00	1776.00
	EUR	2428.00	2499.00
	CNY	283.30	289.50
	RUB	46.60	50.20
	JPY	17.10	17.63
	GBP	2887.00	2987.00
	CHF	1981.00	2076.00



Холбоотой мэдээ

Хойд Солонгост арга хэмжээ авахаар хэлэлцэж байна

Л.Суарес шинэ гутлаараа гангарав

Урьдчилгаа мөнгөгүй ч байртай болох боломж удахгүй нээгдэнэ

Нийслэлийн Мал хамгаалах санг байгууллаа

АНХААРУУЛГА: Уншигчдын бичсэн сэтгэгдэлд Mass.mn хариуцлага хүлээхгүй болно. Mass.mn сайт ХХЗХ-ны журмын дагуу зүй зохисгүй зарим үг, хэллэгийг хязгаарласан тул Та сэтгэгдэл бичихдээ бусдын эрх ашгийг хүндэтгэн үзнэ үү.

Сэтгэгдэл үлдээх

СЭТГЭГДЭЛ ОРУУЛАХ

Нийт 0 сэтгэгдэлтэй

bolloo.mn

Like

10,386 people like bolloo.mn.

Facebook social plugin

- [HotNews](#)
- [Орон нутгийн мэдээ](#)
- [Банк санхүү](#)
- [Гэр бүл](#)
- [Масс репорт](#)
- [Нийгэм](#)
- [Орон нутаг](#)
- [Спорт](#)
- [Уул уурхай](#)
- [Хөл бөмбөг](#)
- [Шударга байцгаая л даа](#)
- [Massmn цөмийн хаягдлын эсрэг](#)
- [Ард түмний индэр](#)
- [Бизнес](#)
- [Дэлхий дахинд](#)
- [Нийслэлийн мэдээ](#)
- [Сурвалжлага](#)
- [Улстөр](#)
- [Фото мэдээ](#)
- [Эдийн засаг](#)
- [Үдшийн шивнээ +18](#)
- [Ярилцлага](#)
- [Teenagers](#)
- [Боловсрол](#)
- [Замын хөдөлгөөн](#)
- [Нийтлэл](#)
- [Сонгууль](#)
- [Технологи](#)
- [уншихыг хориглоно](#)
- [Халуун сэдэв](#)
- [Чөлөөт цаг](#)
- [Эмэгтэйчүүд](#)
- [Эрүүл мэнд](#)
- [Хэн юу гэгчихэв](#)
- [Байгаль орчин](#)
- [Видео мэдээ](#)
- [Иргэн танд](#)
- [Мэндчилгээ](#)
- [Намтар](#)
- [Нүднээс далд юу болов?](#)
- [Сонин хачин](#)
- [Тодруулга](#)
- [Урлаг](#)
- [Хууль эрх зүй](#)
- [Шатахууны хөмсдол](#)

[НҮҮР](#) [БИДНИЙ ТУХАЙ](#) [СУРТАЛЧИЛГАА](#) [САНАЛ ХҮСЭЛТ](#) [ХОЛБОО БАРИХ](#) [RSS](#)

© 2014 МАСС ЭЖЕНСИ ХХК